

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын 9 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа
Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
Аудитор: П.Оюунжаргал
Утас: 86034305 Цахим хаяг: oyunaajaagii@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЕСДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.БАТИЗА ТАНАА

2023.02.17 № 87
танай _____-ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,535,407.00</u>	<u>32,238,093.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	11,378,186.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	11,378,186.00
3121	Төгрөг	0.00	11,378,186.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	11,378,186.00
33	АВЛАГА		440,000.00
335	Бусад авлага		440,000.00
3351	Байгууллагаас авах авлага		440,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,535,407.00	20,419,907.00
351	Түүхий эд материал	525,455.00	345,455.00
35130	Эм боох материал	525,455.00	345,455.00
354	Хангамжийн материал	19,009,952.00	20,074,452.00
35420	Аж ахуйн материал	19,009,952.00	20,074,452.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>893,593,277.48</u>	<u>854,088,827.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	893,593,277.48	854,088,827.47
392	Биет хөрөнгө	853,977,277.52	814,582,827.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	960,931,159.00	960,931,159.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-144,607,742.39	-192,989,076.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,343,452.00	68,379,162.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,473,744.60	-53,873,213.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,471,280.00	36,471,280.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,486,497.78	-33,783,454.69
39217	Ном	25,799,371.29	29,446,971.49
393	Биет бус хөрөнгө	39,615,999.96	39,505,999.92
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-110,000.04	-220,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	39,176,000.00	39,176,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>913,128,684.48</u>	<u>886,326,920.47</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>913,128,684.48</u>	<u>886,326,920.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	913,128,684.48	886,326,920.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,102,661.20	211,102,661.20
51101	Өмч: - төрийн	211,102,661.20	211,102,661.20
512	Хуримтлагдсан үр дүн	-35,766,718.03	-62,568,482.04
51210	Өмнөх үеийн үр дүн	-22,586,431.22	-35,766,718.03
51220	Тайлант үеийн үр дүн	-13,180,286.81	-26,801,764.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	737,792,741.31	737,792,741.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>913,128,684.48</u>	<u>886,326,920.47</u>

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	657,255,849.59	713,064,410.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	64,927,149.59	713,064,410.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	60,405,938.59	654,108,310.20
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	649,287,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	60,405,938.59	4,821,310.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	58,956,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	58,956,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	670,436,136.40	739,866,174.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	670,436,136.40	739,866,174.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	639,865,125.40	690,527,894.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,976,900.00	524,932,914.00
210101	Үндсэн цалин	417,371,600.00	412,683,900.00
210102	Нэмэгдэл	-	101,166,014.00
210104	Урамшуулал	33,916,400.00	11,083,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,971,399.00	66,047,720.00
210201	Тэтгэврийн даатгал	45,052,299.00	44,912,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,729,800.00	5,283,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,783,800.00	4,227,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	946,000.00	1,056,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,459,500.00	10,567,420.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,421,690.00	17,197,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,181,590.00	1,897,000.00
210302	Түлш, халаалт	18,240,100.00	15,300,000.00
2105	Нормативт зардал	812,945.00	11,416,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	405,745.00	180,000.00
210502	Хоол, хүнс	-	11,236,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	597,900.00	1,405,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,405,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,889,091.40	68,327,960.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,817,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,827,411.00	5,322,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,061,680.40	54,187,760.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,571,011.00	49,338,280.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,665,700.00	47,761,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,665,700.00	47,761,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,410.00	1,576,680.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,410.00	1,576,680.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(13,180,286.81)</u>	<u>(26,801,764.01)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(13,180,286.81)</u>	<u>(26,801,764.01)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>596,596,611.00</u>	<u>708,243,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	596,596,611.00	708,243,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	592,075,400.00	649,287,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		649,287,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	58,956,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		58,956,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>592,976,611.00</u>	<u>687,002,914.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	592,976,611.00	687,002,914.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	564,294,300.00	637,664,634.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,976,900.00	524,932,914.00
210101	Үндсэн цалин	416,371,600.00	412,683,900.00
210102	Нэмэгдэл	0.00	101,166,014.00
210104	Урамшуулал	33,916,400.00	11,083,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,971,399.00	66,047,720.00

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	45,052,299.00	44,912,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,729,800.00	5,283,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,783,800.00	4,227,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	946,000.00	1,056,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,459,500.00	10,567,420.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,421,690.00	17,197,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,181,590.00	1,897,000.00
210302	Түлш, халаалт	18,240,100.00	15,300,000.00
2105	Нормативт зардал	1,415,100.00	11,236,400.00
210502	Хоол, хүнс		11,236,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	597,900.00	1,845,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,845,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,716,111.00	15,204,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,882,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,716,111.00	5,322,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,682,311.00	49,338,280.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,777,000.00	47,761,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,777,000.00	47,761,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	886,901.00	1,576,680.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	886,901.00	1,576,680.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,620,000.00</u>	<u>21,240,186.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,620,000.00	9,862,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,620,000.00	9,862,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,620,000.00	9,862,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,620,000.00	9,862,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3,620,000.00</u>	<u>-9,862,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	11,378,186.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		11,378,186.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,102,661.20	737,792,741.31	36,213,609.76	985,109,012.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,102,661.20	737,792,741.31	36,213,609.76	985,109,012.27
C07	Тайлант үеийн үр дүн			-61,546,593.48	-61,546,593.48

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,102,661.20	737,792,741.31	-35,766,718.03	913,128,684.48
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,102,661.20	737,792,741.31	-35,766,718.03	913,128,684.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,102,661.20	737,792,741.31	-35,766,718.03	913,128,684.48
D08	Тайлант үеийн үр дүн			-26,801,764.01	-26,801,764.01
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,102,661.20	737,792,741.31	-62,568,482.04	886,326,920.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	708,243,100.00	695,288,234.00	12,954,866.00	98.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	708,243,100.00	695,288,234.00	12,954,866.00	98.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	656,278,200.00	647,526,634.00	8,751,566.00	98.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,362,100.00	524,932,914.00	4,429,186.00	99.16
210101	Үндсэн цалин	413,321,100.00	412,683,900.00	637,200.00	99.85
210102	Нэмэгдэл	104,958,000.00	101,166,014.00	3,791,986.00	96.39
210104	Урамшуулал	11,083,000.00	11,083,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,048,100.00	66,047,720.00	380.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	44,912,800.00	44,912,800.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,283,700.00	5,283,700.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,227,000.00	4,227,000.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,056,800.00	1,056,800.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,567,800.00	10,567,420.00	380.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,136,100.00	17,197,000.00	939,100.00	94.82
210301	Гэрэл, цахилгаан	2,276,100.00	1,897,000.00	379,100.00	83.34
210302	Түлш, халаалт	15,360,000.00	15,300,000.00	60,000.00	99.61
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	0.00	500,000.00	0.00
2105	Нормативт зардал	11,236,400.00	11,236,400.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	11,236,400.00	11,236,400.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,596,900.00	2,865,900.00	1,731,000.00	62.34

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,596,900.00	2,865,900.00	1,731,000.00	62.34
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,698,600.00	24,046,700.00	1,651,900.00	93.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,803,300.00	17,151,400.00	1,651,900.00	91.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,895,300.00	6,895,300.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,964,900.00	47,761,600.00	4,203,300.00	91.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,964,900.00	47,761,600.00	4,203,300.00	91.91
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,964,900.00	47,761,600.00	4,203,300.00	91.91
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	708,243,100.00	706,666,420.00	1,576,680.00	99.78
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	649,287,000.00	649,287,000.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	649,287,000.00	649,287,000.00	0.00	100.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих			0.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,956,100.00	57,379,420.00	1,576,680.00	97.33
132001	Орон нутгийн төсвөөс	58,956,100.00	57,379,420.00	1,576,680.00	97.33
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		11,378,186.00	-11,378,186.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	0.00	0.00
610001	Төсвийн байгууллага			0.00	0.00
610002	Төсвөөс гадуур байгууллага			0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47.00	44.00	3.00	93.62
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	26.00	2.00	92.86
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	5.00	4.00	1.00	80.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)			0.00	0.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД			0.00	0.00
630001	Төрийн өмчит ЕБС	276.00	276.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургууль нь боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Бага боловсрол олгох Алдаагүй зөв бичиж зөв уншиж чаддаг, зөв дадал хэвшилтэй хүүхэд төлөвшүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг баяжуулах, багшийг чадавхижуулах замаар сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх: Үүний тулд бие даан сурах арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх
- Хүүхдийг төлөвшүүлэх: Үүний тулд эцэг эх,асран хамгаалагчидтай хамтран ажиллах,тэдэнд сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгөх, зөв дадал хэвшилд сургах
- Сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, ардчилал, шударга ёс, ил тод байдал, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагаа зохион байгуулна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн захирлын оны дугаар сарын ны өдрийн тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26.8 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	11.378.2	11.378.2
Авлага	-	440.0	440.0
Бараа материал	19.535.4	20.419.9	884.5
Үндсэн хөрөнгө	893.593.3	854.088.8	(39.504.5)
Нийт хөрөнгө	913.128.7	886.326.9	(26.801.8)
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	913.128.7	886.326.9	(26.801.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	913.128.7	886.326.9	(26.801.8)

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 11.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан батлагдсан төсвөөс бараа үйлчилгээний зардлыг хэмнэснээс үүдэлтэй бөгөөд нийт бараа үйлчилгээний зардлын хэмнэлтээс 7.1 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 62.8 хувийг эзэлж байна.

Бараа материалын данс 0.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материалын орлоготой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 39.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 9.8 сая, бусад эх үүсвэрээс 4.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 54.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 731.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 57.4, нийт зарлагыг 788.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 80.3 зардлыг сая төгрөгөөр бууруулж 708,2 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 649.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 58.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 649.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 57.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 695.3 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үдийн цайны төсвийг 4.2 сая төгрөгөөр, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	58.956.1	57.379.42	1.576.68	97.33
2	Эрүүл мэндийн арга хэмжээ	2.114.6	1.069.5	1.045.1	50.58
3	Боловсролын арга хэмжээ	460.689.1	456.591.5	4.097.6	99.11
4	Үдийн цай хөтөлбөр	63.201.3	58.998.0	4.203.3	93.35
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7.495.0	7.192.0	303.0	95.96
6	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	4.137.2	4.137.2	0	100.00
7	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	108.891.7	107.438.4	1.453.3	98.67
8	Сургалт семинар	919.4	919.4	0	100.00
9	Байр ашиглалтын үйлчилгээ	1.838.7	1.562.8	275.9	84.99
	Дүн	708.243.1	695.288.2	12.954.9	98.17

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургууль 2022 онд нэмэлт төсөв авч зарцуулаагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор П.Оюунжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 739,8 сая төгрөгөөс

Өлгий сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.5 хувиар буюу 11,0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

Тус аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 оны 10 сард хийсэн “Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх аудит” нийцлийн аудитаар шилэн данстай холбоотой аливаа зөрчил дутагдал илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитын дүгнэлтээр зөрчил дутагдал илрээгүй өгсөн зөвлөмж байхгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										